

SSAVEGOLD ҮНЭРТЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1. Үйлчилгээний нөхцөлийн зорилго

Энэхүү Үйлчилгээний нөхцөл нь SSAVEGOLD брэндийн үнэртэй ус, бахуур, үнэртүүлэгч болон бусад бүтээгдэхүүнийг худалдан авах, борлуулах, захиалах, түгээх, платформ ашиглахтай холбоотойгоор хэрэглэгч, худалдан авагч, бие даасан борлуулагч болон **“Оюуны Хүрдэн ПЕРФЮМ” ХХК** /цаашид “Компани” гэх/-ийн хооронд үүсэх харилцааг зохицуулна.

Хэрэглэгч нь энэхүү платформоор дамжуулан бүтээгдэхүүний мэдээлэл авах, захиалга өгөх, худалдан авалт хийх, бие даасан борлуулагчаар бүртгүүлэх болон Компанийн маркетингийн үйл ажиллагаанд оролцох боломжтой.

Брэндийн албан ёсны нэр: SSAVEGOLD
Компанийн нэр: “Оюуны Хүрдэн ПЕРФЮМ” ХХК
Албан ёсны вебсайт: ssavegold.com

1.2. Оюуны өмч

SSAVEGOLD нэр, лого, барааны тэмдэг, бүтээгдэхүүний нэршил, сав баглаа боодлын загвар, платформын дизайн, текст, зураг, аудио, видео, график болон бусад контент нь Компанийн өмч байна.

Компанийн албан ёсны бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр дээрх материалыг бүхэлд нь болон хэсэгчлэн хуулбарлах, өөрчлөх, нийтлэх, худалдааны зорилгоор ашиглах, бусдад дамжуулахыг хориглоно.

Компанийн оюуны өмчийг зөвшөөрөлгүй ашигласан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

1.3. Бүтээгдэхүүний мэдээлэл

Компани нь бүтээгдэхүүний нэр, төрөл, хэмжээ, найрлага, зориулалт, үнэ, урамшуулал болон ашиглах зааврын талаарх үнэн зөв мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх үүрэгтэй.

Бүтээгдэхүүний савлагаа, шошго, өнгө, дизайнд үйлдвэрлэлийн болон хөгжүүлэлтийн шаардлагаар бага хэмжээний өөрчлөлт орж болно. Ийм өөрчлөлт нь бүтээгдэхүүний үндсэн зориулалт, хэмжээ, чанарыг алдагдуулахгүй байна.

Үнэрийн мэдрэмж нь хүн бүрийн арьсны онцлог, үнэрлэх мэдрэмж, орчны температур болон хэрэглээний байдлаас шалтгаалан ялгаатай байж болно.

1.4. Хэрэглэгчийн мэдээлэл

Хэрэглэгч, худалдан авагч болон бие даасан борлуулагч нь платформд бүртгүүлэхдээ өөрийн нэр, утасны дугаар, хүргэлтийн мэдээлэл, төлбөр тооцоо болон бусад шаардлагатай мэдээллийг үнэн зөв оруулах үүрэгтэй.

Буруу, дутуу, бусдын мэдээллийг зөвшөөрөлгүй ашиглан бүртгүүлснээс үүсэх эрсдэл, хохирлыг тухайн хэрэглэгч өөрөө хариуцна.

1.5. Нөхцөлийг хүлээн зөвшөөрөх

Хэрэглэгч нь платформд бүртгүүлэх, захиалга баталгаажуулах эсвэл:

“Үйлчилгээний нөхцөл болон Нууцлалын бодлогыг хүлээн зөвшөөрч байна”

гэсэн сонголтыг хийснээр энэхүү Үйлчилгээний нөхцөл болон Нууцлалын бодлоготой бүрэн танилцаж, хүлээн зөвшөөрсөнд тооцогдоно.

Энэхүү нөхцөл нь хэрэглэгч платформд бүртгүүлсэн эсвэл захиалга баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

ХОЁР. БҮТЭЭГДЭХҮҮН ЗАХИАЛАХ, ХУДАЛДАН АВАХ

2.1. Захиалга баталгаажих

SSAVEGOLD бүтээгдэхүүнийг худалдан авахдаа захиалгын нийт төлбөрийг 100 хувь төлсний дараа захиалга баталгаажна.

Төлбөр бүрэн төлөгдөөгүй захиалгыг Компани баталгаажсан захиалгад тооцохгүй бөгөөд бүтээгдэхүүн нөөцлөх үүрэг хүлээхгүй.

2.2. Бүтээгдэхүүний төрөл

Платформоор дараах төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалж болно:

- Үнэртэй ус;
- Тосон үнэртэн;
- Бахуур;
- Машин болон өрөөний үнэртүүлэгч;
- Үнэртүүлэгч төхөөрөмж;
- Бахуурын сав, бойпор, нүүрс;
- Бэлгийн багц;
- Дээж болон тестер;
- SSAVEGOLD брэндийн бусад бүтээгдэхүүн.

2.3. Үнэ

Бүтээгдэхүүний үнэ нь платформ дээр захиалга баталгаажуулах үеийн үнээр тооцогдоно.

Түүхий эд, валютын ханш, тээвэр, гааль, татвар болон үйлдвэрлэлийн зардлын өөрчлөлтөөс шалтгаалан Компани бүтээгдэхүүний үнийг шинэчлэх эрхтэй.

Үнэ өөрчлөгдөхөөс өмнө төлбөрөө бүрэн төлж баталгаажуулсан захиалгад хуучин үнэ үйлчилнэ.

2.4. Нөөцийн үлдэгдэл

Бүтээгдэхүүн дууссан, үйлдвэрлэл саатсан эсвэл захиалгын тоо нөөцөөс давсан тохиолдолд Компани хэрэглэгчид мэдэгдэж:

- ижил үнэлгээтэй өөр бүтээгдэхүүн санал болгох;
- захиалгыг дараагийн үйлдвэрлэл хүртэл хүлээлгэх;
- эсвэл төлсөн мөнгийг буцаан олгох боломжтой.

Сонголтыг хэрэглэгчтэй харилцан тохиролцоно.

ГУРАВ. БИЕ ДААСАН БОРЛУУЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Бүртгэл

Платформын шаардлагыг хангасан иргэн SSAVEGOLD-ийн бие даасан борлуулагчаар бүртгүүлж, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах болон маркетингийн төлөвлөгөөнд заасан урамшуулалд хамрагдах эрхтэй.

Бие даасан борлуулагч нь Компанийн ажилтан, төлөөлөгч, салбар нэгж биш бөгөөд өөрийн үйл ажиллагаа, татвар, зардал, хэрэглэгчтэй байгуулсан харилцаагаа өөрөө хариуцна.

3.2. Борлуулалтын зарчим

Бие даасан борлуулагч нь бүтээгдэхүүний найрлага, үйлчилгээ, үр нөлөө, орлого, урамшууллын талаар худал, хэтрүүлсэн, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөхийг хориглоно.

Бүтээгдэхүүнийг эмчилгээний зориулалттай, өвчин эдгээдэг, баталгаатай ашиг орлого өгдөг мэтээр сурталчилж болохгүй.

3.3. Урамшууллын эрх

Борлуулалтын болон маркетингийн урамшууллыг зөвхөн:

- бодитоор хийгдсэн, бүрэн төлөгдсөн захиалга;
- Компанийн системд бүртгэгдсэн борлуулалт;
- буцаалт, цуцлалт хийгдээгүй гүйлгээ;
- татварын болон бүртгэлийн шаардлагыг хангасан тохиолдолд тооцно.

Бие даасан борлуулагч нь өөрийн олсон орлого, урамшууллыг Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу тайлагнах, татвар төлөх үүрэгтэй.

Шаардлагатай татварын мэдээлэл, баримт бичгээ бүрдүүлээгүй тохиолдолд урамшуулал олголтыг шаардлага хангах хүртэл түр хойшлуулж болно.

3.4. Хориглох үйлдэл

Бие даасан борлуулагч дараах үйлдэл гаргахыг хориглоно:

- Бусдыг хүчээр болон төөрөгдүүлэн бүртгүүлэх;
- Зээлээр бүтээгдэхүүн авахыг Компаниас шаардах;
- Компанийн зөвшөөрөлгүй үнэ тогтоох, хуурамч хямдрал зарлах;
- Хуурамч бүртгэл, давхар аккаунт үүсгэх;
- Бусдын нэр, мэдээллийг зөвшөөрөлгүй ашиглах;
- Бүтээгдэхүүний шошго, савлагаа, хугацаа, кодыг өөрчлөх;
- Компанийн нэр хүндэд санаатайгаар хохирол учруулах;
- Сүлжээ хооронд хүн шилжүүлэх, бусдын багт хууль бусаар нөлөөлөх;
- Бүтээгдэхүүн заавал нөөцлөхийг бусдаас шаардах;
- Баталгаагүй орлого амлах.

Зөрчлийн шинж чанараас шалтгаалан сануулах, урамшуулал түр зогсоох, бүртгэлийг хаах эсвэл гэрээг цуцлах арга хэмжээ авч болно.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Компанийн эрх

Компани дараах эрхтэй:

- Үйлчилгээний нөхцөл зөрчсөн хэрэглэгчийн нэвтрэх эрхийг түр хаах, цуцлах;
- Хуурамч, сэжигтэй гүйлгээг шалгах;
- Шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл, нотлох баримт шаардах;
- Хууль бус үйл ажиллагааны шинж илэрсэн тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдээлэх;
- Бүтээгдэхүүний үнэ, савлагаа, нэр төрөл, маркетингийн төлөвлөгөөг шинэчлэх;
- Техникийн шинэчлэл, засварын үед платформын үйл ажиллагааг түр зогсоох.

4.2. Компанийн үүрэг

Компани дараах үүрэгтэй:

- Платформын хэвийн, найдвартай ажиллагааг хангах;
- Хэрэглэгчийн хувийн мэдээллийг хууль тогтоомжийн дагуу хамгаалах;
- Бүтээгдэхүүн, үнэ, захиалга, урамшууллын талаар үнэн зөв мэдээлэл өгөх;
- Хэрэглэгчийн хүсэлт, санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;
- Захиалга, төлбөр, борлуулалттай холбоотой цахим мэдээллийг зохих журмын дагуу хадгалах;
- Үйлчилгээний нөхцөлд орсон чухал өөрчлөлтийг хэрэглэгчдэд мэдэгдэх.

4.3. Нөхцөл шинэчлэх

Компани нь хууль тогтоомж, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн болон платформын өөрчлөлттэй холбоотойгоор энэхүү Үйлчилгээний нөхцөлийг шинэчлэх эрхтэй.

Шинэчилсэн нөхцөлийг платформд байршуулснаар хүчин төгөлдөр болно. Хэрэглэгч платформыг үргэлжлүүлэн ашигласан бол шинэчилсэн нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

ТАВ. ХЭРЭГЛЭГЧ, ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Хэрэглэгчийн эрх

Хэрэглэгч дараах эрхтэй:

- Бүтээгдэхүүний талаар үнэн зөв мэдээлэл авах;
- Захиалга болон төлбөрийн мэдээллээ шалгах;
- Өөрийн хувийн мэдээллийг хэрхэн ашиглаж байгаа талаар мэдээлэл авах;
- Буруу мэдээллээ засуулах хүсэлт гаргах;
- Платформ ашиглахаас татгалзах, аккаунтаа хаалгах;
- Үйлчилгээ, бүтээгдэхүүн, нууцлал, аюулгүй ажиллагаатай холбоотой санал, гомдол гаргах;
- Үйлдвэрлэлийн гэмтэлтэй бүтээгдэхүүнийг журмын дагуу солиулах.

5.2. Хэрэглэгчийн үүрэг

Хэрэглэгч дараах үүрэгтэй:

- Үйлчилгээний нөхцөлтэй бүрэн танилцаж, дагаж мөрдөх;
- Бүртгэлийн мэдээллээ үнэн зөв оруулах;
- Аккаунт болон нууц үгийн нууцлалыг хамгаалах;
- Захиалгын төлбөрийг бүрэн төлөх;
- Бүтээгдэхүүнийг зориулалтын дагуу ашиглах;
- Харшил, арьсны эмзэг байдал болон эрүүл мэндийн онцлогоо өөрөө харгалзан үзэх;
- Аккаунтыг гуравдагч этгээд ашигласан байж болзошгүй тохиолдолд Компанид нэн даруй мэдэгдэх.

5.3. Аккаунтын аюулгүй байдал

Хэрэглэгчийн аккаунт, нууц үг, баталгаажуулах кодыг бусдад дамжуулсан, алдсан эсвэл хамгаалаагүйгээс үүссэн хохирлыг Компани хариуцахгүй.

Хэрэглэгчийн зөвшөөрөлгүй нэвтрэлт илэрсэн тохиолдолд Компани тухайн аккаунтыг шалгалт дуустал түр хааж болно.

5.4. Хориглох агуулга

Платформ болон Компанийн албан ёсны цахим сувгуудад:

- Худал, төөрөгдүүлсэн мэдээлэл нийтлэх;
- Хууль бус үйл ажиллагааг сурталчлах;
- Бусдын нэр төр, алдар хүндэд халдах;
- Хувийн мэдээлэл, нууц задруулах;
- Доромжилсон, сүрдүүлсэн, ялгаварлан гадуурхсан агуулга нийтлэх;
- Бүтээгдэхүүний талаар санаатайгаар хуурамч мэдээлэл тараахыг хориглоно.

ЗУРГАА. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

6.1. Үнэртэй ус

Үнэртэй усыг зөвхөн гадуур хэрэглэнэ. Нүд, ам, салст бүрхэвч болон гэмтсэн арьсанд хүргэхгүй байна.

Арьс эмзэг, харшилтай хэрэглэгч бүтээгдэхүүнийг эхлээд арьсны жижиг хэсэгт туршиж хэрэглэнэ.

Цочрол, тууралт, загатнах болон таагүй шинж тэмдэг илэрвэл хэрэглээг нэн даруй зогсооно.

6.2. Бахуур болон нүүрс

Бахуур, бойпор, нүүрсийг галын аюулгүй байдлыг хангасан, агаарын солилцоо сайтай орчинд хэрэглэнэ.

Асаалттай нүүрс, бахуурыг хүүхэд, амьтан болон шатамхай зүйлээс хол байлгана.

Асаалттай бүтээгдэхүүнийг хараа хяналтгүй орхихыг хориглоно.

Утаанд мэдрэмтгий, амьсгалын замын асуудалтай хүн хэрэглэхдээ болгоомжтой байна.

6.3. Машин болон өрөөний үнэртүүлэгч

Үнэртүүлэгч шингэнийг уух, арьс болон нүдэнд хүргэхийг хориглоно.

Асгарсан тохиолдолд савлагаа, тавилга, машины эд ангийг гэмтээхээс сэргийлж нэн даруй арчина.

6.4. Хадгалалт

Бүтээгдэхүүнийг:

- Нарны шууд тусгалаас хол;
- Хэт халуун болон хүйтэн орчноос хамгаалсан;
- Хуурай, сэрүүн газар;
- Хүүхэд хүрэхээргүй орчинд хадгална.

Буруу хадгалалт, зориулалтын бус хэрэглээнээс үүсэх хохирлыг Компани хариуцахгүй.

ДОЛОО. БУЦААЛТ, СОЛИЛТ

7.1. Буцаах боломжгүй бүтээгдэхүүн

Үнэртэй ус, тосон үнэртэн, бахуур, үнэртүүлэгч зэрэг нь хувийн хэрэглээний болон үнэрийн шинж чанартай бүтээгдэхүүн тул сав баглаа боодол нь задарсан, лац эвдэрсэн, хэрэглэсэн бүтээгдэхүүнийг амт, үнэр таалагдаагүй гэх үндэслэлээр буцаахгүй.

7.2. Үйлдвэрлэлийн гэмтэл

Дараах тохиолдолд бүтээгдэхүүнийг шалган сольж болно:

- Сав хагарсан;
- Шүршигч ажиллахгүй;
- Бүтээгдэхүүн асгарсан;
- Буруу бүтээгдэхүүн хүргэгдсэн;
- Савлагааны битүүмжлэл үйлдвэрлэлийн шалтгаанаар алдагдсан;
- Захиалсан хэмжээ, төрөлтэй тохироогүй.

Хэрэглэгч бүтээгдэхүүнийг хүлээн авснаас хойш **48 цагийн дотор** зураг, видео болон захиалгын мэдээллийн хамт Компанид мэдэгдэнэ.

7.3. Солих нөхцөл

Бүтээгдэхүүн нь ашиглаагүй, анхны савлагаа, шошго, дагалдах хэрэгсэлтэйгээ бүрэн байх шаардлагатай.

Хэрэглэгчийн буруугаас бүтээгдэхүүн гэмтсэн, буруу хадгалсан, зориулалтын бусаар ашигласан бол солих, буцаах хүсэлтийг хүлээн авахгүй.

НАЙМ. СИСТЕМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

8.1. Сэжигтэй нэвтрэлт

Хэрэглэгч өөрийн бүртгэлээр бусад этгээд нэвтэрсэн байж болзошгүй гэж үзвэл нэн даруй Компанид мэдэгдэнэ.

Холбоо барих мэдээлэл:

“Оюуны Хүрдэн ПЕРФЮМ” ХХК

Утас: **72996699**

Цахим шуудан: oyuniikhurdenkristal@gmail.com

Вебсайт: ssavegold.com

8.2. Давагдашгүй хүчин зүйл

Байгалийн гамшиг, гал түймэр, үер, газар хөдлөлт, дайн, үймээн самуун, халдварт өвчин, төрийн байгууллагын шийдвэр, хил гаалийн саатал, тээврийн тасалдал, цахилгаан болон интернетийн доголдол зэрэг Компанийн хяналтаас гадуурх нөхцөлөөс шалтгаалан үйлчилгээ саатсан тохиолдолд Компани шууд хариуцлага хүлээхгүй.

Компани үйлчилгээ болон нийлүүлэлтийг хэвийн болгохын тулд боломжит арга хэмжээг авна.

ЕС. ПЛАТФОРМ АШИГЛАХАД ХОРИГЛОХ ҮЙЛДЭЛ

SSAVEGOLD-ийн платформыг дараах зорилгоор ашиглахыг хориглоно:

9.1. Хууль зөрчсөн, залилан мэхэлсэн эсвэл бусдад хохирол учруулах аливаа үйлдэл хийх;

9.2. Хуурамч баримт бичиг, хуурамч мэдээлэл ашиглан бүртгүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээ, урамшуулал авахыг завдах;

9.3. Платформ болон түүний дэд системд хууль бусаар нэвтрэх, хакердах, вирус, хортой код тараах, системийн ажиллагааг доголдуулах;

9.4. Бусад хэрэглэгчийн бүртгэл, мэдээлэл, урамшуулал болон хууль ёсны эрхэд халдах;

9.5. Компанийн нэр, лого, бүтээгдэхүүний зураг, контентыг зөвшөөрөлгүй ашиглан хуурамч бүтээгдэхүүн болон үйлчилгээ сурталчлах;

9.6. Платформын мэдээллийг хуулбарлан өрсөлдөгч бизнес, хуурамч вебсайт, аппликейшн болон цахим хуудас үүсгэх

АРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР, ТООЦОО

10.1. Төлбөрийн хэлбэрээс шалтгаалан банк, төлбөрийн байгууллага болон цахим төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн гүйлгээний шимтгэл харилцан адилгүй байж болно.

10.2. Хэрэглэгч болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хооронд үүссэн шимтгэл, банкны саатал, дансны хязгаарлалт болон бусад асуудлыг Компани шууд хариуцахгүй.

10.3. Төлбөрийн гүйлгээний утга дээр хэрэглэгчийн нэр, утасны дугаар, захиалгын дугаарыг үнэн зөв бичнэ.

Буруу дансанд төлбөр шилжүүлсэн эсвэл гүйлгээний мэдээллийг буруу оруулснаас үүсэх эрсдэлийг хэрэглэгч өөрөө хариуцна.

10.4. Бүтээгдэхүүний захиалга платформоор өдөр бүр хүлээн авч болно.

Захиалга баталгаажуулах, хэрэглэгчийн хүсэлтэд хариу өгөх үйлчилгээ нь өдөр бүр **08:00–19:00 цагийн хооронд** ажиллана.

АРВАН НЭГ. ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ

11.1. Компани нь хэрэглэгчийн нэр, утасны дугаар, цахим шуудан, хүргэлтийн мэдээлэл, захиалга, төлбөрийн мэдээллийг зөвхөн үйлчилгээ үзүүлэх, захиалга баталгаажуулах, урамшуулал тооцох, хэрэглэгчтэй холбоо барих болон хуульд заасан үүргийг биелүүлэх зорилгоор ашиглана.

11.2. Хэрэглэгчийн мэдээллийг хуульд заасан үндэслэл, хэрэглэгчийн зөвшөөрөл эсвэл үйлчилгээ үзүүлэхэд зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй.

11.3. Хууль, шүүх, прокурор, цагдаа, татвар болон бусад эрх бүхий байгууллагын хууль ёсны шаардлагын дагуу шаардлагатай мэдээллийг гаргаж өгч болно.

АРВАН ХОЁР. ХАРИУЦЛАГА

12.1. Аль нэг тал энэхүү Үйлчилгээний нөхцөл болон Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөнөөс нөгөө талд бодит хохирол учруулсан бол буруутай тал хариуцлага хүлээнэ.

12.2. Хэрэглэгч бүтээгдэхүүний заавар, анхааруулгыг мөрдөөгүй, буруу хадгалсан, зориулалтын бусаар хэрэглэсэн болон гуравдагч этгээдэд буруу мэдээлэл өгснөөс үүссэн хохирлыг Компани хариуцахгүй.

12.3. Бие даасан борлуулагчийн Компанийн зөвшөөрөлгүйгээр өгсөн амлалт, баталгаа, зээл, өр төлбөр, хуурамч мэдээлэл болон бусад хувийн тохиролцоог Компани хариуцахгүй.

АРВАН ГУРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

13.1. Энэхүү Үйлчилгээний нөхцөлтэй холбоотой аливаа санал, гомдол, маргааныг талууд эхний ээлжид харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

13.2. Хэрэглэгч санал, гомдлоо захиалгын дугаар, холбогдох баримт, зураг болон тайлбарын хамт Компанийн албан ёсны холбоо барих сувгаар ирүүлнэ.

13.3. Талууд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага болон шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРВАН ДӨРӨВ. ЭЦСИЙН ЗААЛТ

14.1. Энэхүү Үйлчилгээний нөхцөл нь SSAVEGOLD платформ, бүтээгдэхүүний худалдаа, захиалга болон бие даасан борлуулагчийн үйл ажиллагаанд хамаарна.

14.2. Энэхүү нөхцөлд тусгагдаагүй асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн баталсан бусад журам болон талуудын хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

14.3. Бие даасан борлуулагчийн урамшуулал, цол, оноо, татвар, ёс зүй болон маркетингийн дэлгэрэнгүй зохицуулалтыг **“SSAVEGOLD маркетингийн төлөвлөгөө”**, **“Бие даасан борлуулагчийн гэрээ”** болон холбогдох журмаар тусад нь зохицуулна.

14.4. Хэрэглэгч энэхүү Үйлчилгээний нөхцөлийг уншиж танилцан, ойлгож, сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрсөн байна.

“Оюуны Хүрдэн ПЕРФЮМ” ХХК

SSAVEGOLD брэнд

Вебсайт: ssavegold.com

Утас: **72996699**

Цахим шуудан: oyuniikhurdenkristal@gmail.com